

НИЙТЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ

С. Эрдэнэ.
Төрийн шагналт
зохиолч.

КАМПУЧИЙН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Миний багад отгон дүүгий минь үрчилж авсан айлын авга лам Дашцэрэн гавж Жагар гэгч Энэтхэг орны тухай сонин юм ярьдагсан. Тэр залуудаа Бурхан багшийн ном тавьсан Очирт суурин буюу Энэтхэгийн Варанаси хот очиж байжээ. Тэгээд Жагарын орон, Доржлин, Тай улс, Камбожи гээд цөм бурхны орон байдаг гэнэ. Тэдгээр Бурхны орнуудын нэг хэмээгдэгч Камбожи буюу өнөөгийн Кампучид уржнан намар Вьетнамын нийслэл Ханойгоос очиж ганцхан өдөр байх завшган олдсон юм. Буддын шашны нэг төв болсноороо бурхны орон хэмээгдэгч эртний түүхт Кампучид Хятадын маоист зандалчидын хар гайгаар ямар гэг- чийн үзэгдэж дуулдаагүй аюул гамшиг учирсныг өгүүлэх юун. Зүүн өмнөд азийн хамгийн эртний түүх соёлт энэ сайхан орны найман сая ард түмнийг Пол Потын алуурчид Хятадын удирдагчидийн турхирснаар хүйс тэмтрэн, уг удмаар нь үгүй хийхийн даваан дээр эх орон, улс үндсээ аврах хүчин босч Пол Потын дээрэмчидийг хөөн зайлуулсан билээ. Найман сая Кхмер хүн ардын гурван сая илүүг хорхой шавьж мэтээр алж тонилгосон Пол Потын дээрэмчидийн яргалалын тухай дэлхий дахинаараа түрхрэн цууриатаж байсан өдрүүд саяхныхаа. Нэг улс үндэстэн дотроос тийм хүн бусын араатнууд гарч ах дүү, амраг садангаа үзэшгүй бузар муухайгаар талан хөнөөж буйд итгэхэд хэцүү байсан. Гэвч үнэн бодит явдлын хаагуур гарах билээ. Хэвлэл мэдээллийн баримт сэлтээс гайхаш төрөн үзсэнээ нүдээр үзсэн хүний эргэлзлэл бүрэн арилах нь мэдээж. Ханойгоос Пномпень уруу нисч явахдаа энэ тухай ярилцаж явлаа. Вьетнамын эртний их яруу найрагч Нгуен Чайгийн ойд оролцсон эрдэмтэн, зохиолч бид Пол Потын дээрэмчдийн өдүүлсэн аюумшигт хэргийн тухай өөрсдийн орны болоод гадаад орны хэвлэл мэдээллийн хэрэгслээс үзэж сонссноо хуваалцан, тэр хэргийг цаг үеийн болоод хүн төрөлхтний үүднээс хэрхэн үзэх тухай санаа бодлоо солилцоход хүний түүхэнд нэг үндэстэн ястны дотоод мөргөлдөөн, иргэний дайн, нэг биш удаа гарсан гэлээ ч бүхэл бүтэн ард түмнийг харийн дайсны биш өөрсдийнх нь га- раар аймаглан устгуулах аюул ойрхи түүхэн үед гарсан баримтыг олоход хэцүү гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байв. Харин тэр ер бусын аюул гамшигийн шалтгааныг ялангуяа Франц, Швед зэрэг барууны эрдэмтэн, зохиолчид хятадаас болсон гэдэгт бүрэн итгэхгүй буюу Кхмерчүүдийн өөрсдийн дундаас эрж ч болох юм гэсэн маягийн юм ярьж байв. Гэвч удалгүй нүдээрээ үзэж чихээрээ сонсох юм чинь итгэх болихоо өөрсдөө мэднэ биз. Зүгээр хар ухаанаар бодоход л гаднын гар хөл, хорт муухай санаагүйгээр тийм юм болох гэж байх уу? Хятадын маоистууд ганц Кампучи биш хөрш зэргэлдээ бүх улс гүрэнд тийм хоосруулах зай харж, тэр алсын хорт санаагаа биелүүлэхэд ашиглах ямар нэг самуун мөргөлдөөн хэзээ хаана гарахыг нүд бүлтийтэл ширтэн анаж байгааг бид сайн мэддэг хойно жишээ нь миний хувьд эргэлзэх төөрөлдөх

явдал өчүүхэн ч байсангүй. Гэвч нүдээрээ харах бас өөр.

Өмнөдийн халуун орны битүү ширэнгэ дундуур далай их Меконг мөрөн улаан хоормог усаа яаралгүй эвхрүүлэн тэр үзүүр хязгааргүй бөглүү ширэнгэ дунд энд тэнд хаа нэгтэй үлд шарх шиг гялтайх чөлөө зайд хоргодсон хот тосгод цөм усан дунд арчаагүй бүртийнэ. Ийм нэвсийсэн их ой ширэнгэ, шавар усан дунд Бурхны орон гэж бишрэгдэм гайхамшигт сайхан хот суурин, орд харш байгуулсан Кхмерийн ард түмэнд учир сан түмэн зовлонг сэтгэлээрээ ч гэсэн хуваалцсандаа би гэж бодолхийлэн явтал Ту-134-ийн шуумайх мөнгөн далавч дор Пномпенийн барилга байшин ярайн харагдаад, онгоц доошилмогц өнөөх их усан далай халуун орны ганган наргил таруухан ургасан хуурай газраар солигдох нь тэрээ. Пномпенийг зүүн өмнөд Азийн хамгийн сайхан хот гэлцэнэ. Пол Потынхны яргалалын үед тэр хотын зураг сонин хэвлэлийн хуудаснаас салдаггүй байлаа. Тэр сайхан хотын оршин суугчидыг хөгшид хүүхэдгүй хэдхэн өдрийн дотор үлдэн гаргаж хоослоод, түүх соёлын газар, эмнэлэг сургууль юу дайралдсан бүхнийг үйлдвэрийн суурь машинууд банкныхаа мөнгөн тэмдэгт, айлын гэр орон цөмийг галзуу араатан орсон мэт эв- дэж сүйтгэн, урж тасдан хаяжээ. Кхмерийн ард түмний олон үеийнхний хөлс хүчээр бүтсэн юуг ч тэд өршөөж хайрласангүй. Тэдэнд үнэтэй цайтай сэтгэл хар буух юм гэж юу ч байсангүй. Ердөө л эвдээд бай! Алаад бай! гэж орь дуу тавьцгаан хүмүүсийн дунд гэнэт орж ирсэн урьд хожид үзэгдээгүй араатны сүрэг мэт цусан зам татуулжээ. Хэдхэн өдрийн дотор бүхэл бүтэн улс гүрний нийслэл, хэдэн мянган жилийн түүх соёлын дурсгал хадгалсан, орчин үеийн их хотын бүх шинж бүрдсэн, тэгээд бас бага ч үгүй, их ч үгүй сая гаруй хүнтэй хотыг эзэнгүй мөртөө бүтэн босоо барилга байшинтай хоосон сав болгоно гэдэг хүний санаанд багташгүй биш үү? Хүн ардыг хот орноос нь хөөхийг нь хөөж, алахыг нь алж хоослоод сүүлд нь өөрсдөө эзэгнэж суух гэсэн өөрсдийн ч байг, харийн ч байг зандалчидыг юутай зүйрлэлтэй вэ? Дээрэмчдийн толгойлогч Пол Пот Пномпенийг тэгж хоосолсон тухайгаа Хятадын маоист удирдагчдад баяр болгон мэдэгдэж байжээ. Тэгээд ч Бээжингийнхэн Пномпений ганган цагаан орд харшуудад налайн сууж, амьд мэнд үлдсэн Кхмерчүүдээр үүдний боол хийж зүүдэлж байсан бизээ.

Пномпений нисэх онгоцны буудлаас хот руу явж байхдаа энэ мэтийг бодож явлаа. Пномпень үнэхээр сайхан хот юм. Зах уруугаа орчин цагийн үйлдвэр барилга, орон сууцны байшингуудтай төв уруугаа эртний дуган сүм, орд харш, хөшөө дурсгал түүний дотор хан агсан Нордом Сианукийн бор улаан гантиг чулуун орд, өргөн шулуун гудамжтай ажээ. Жараад оны дундуурсан байх Камбоджийн жонон Нордом Сианук гэгч дэгжин цагаан эр манай Улаанбаатарт ирэхдээ Франц хатан, ордныхоо бүжигч дууч хүүхнүүдийг дагуулан айлчилж ирээд Кхмерийн дуу бүжгийг үзүүлж гайхуулж байлаа. Гэтэл тэр мөнөөхөн самуун дэгдээгчдийн гайгаар хан ширээнээсээ хальж, улаан бор гантиг ордноосоо хөөгдөөд толгой хоргодох газар эрэлхийлэн Европ, Азиар хэрэн хэссээр эцэст Бээжинд нүхээ малтаж, түүнийг төрүүлж өргөмжилсөн ард түмэн, тэр сайхан орд харш барьж өгсөн ард түмнийг нь хүйс тэмтэрсэн зандалчидын талд орж баян тансаг орд харшаа Бээжингийн зочид буудлаар сольсондоо гуниж гутрахдаа Бээжин дуурийн театрын найрал хөгжмийн аялгуунд дуу дуулж, улс орныг нь сүйрүүлэхэд тухирсан хятадын удирдагчидыг зугаацуулж яваа нь юутай гутамшиг.

Пномпений өнөөх сая гаруй оршин суугчдаас амьд мэнд үлдэгсэд ий буцаж ирж, амьдрал шинээр эхлэн, хоосорсон хот эзэнтэй болж, балчир зүрхэндээ зовлон хагацлыг амархан мартсан хүүхдүүдийн инээд наадмаар цалгиж байна.

Ардын засаг тогтож, эх орноо мөхөл сүйрлээс аварсныг зөвхөн тэр хүүхдүүдийн баясгалант инээднээс мэдэж болох байлаа. Пол Потынхон олон мянган хүүхдүүдийг улангассан араатан зугаа хийх мэт алж талан, бас олон мянгаар нь өнчрүүлсэн юм. Тэд нялх балчир хүүхдүүдийг ч өршөөсөнгүй. Пол Потынхны тамын шорон байсан дунд сургуулийн байшингийн хэдэн тасалгааны хана дүүрэн наасан алагдагсдын гэрэл зургийн тал хувь нь дандаа бага балчир хүүхэд ажээ. Ард түмнийг үр үндэсгүй болгох гэсэн жинхэнэ аймаглан устгал гэгч тэр юм. Гэвч Кхмерийн ард түмэнд үр үндсээ таслуулахгүй чадал хүрсэн билээ. Сианукийн ордны нэг жигүүрт байгуулсан урлагийн сургуулийн хүүхдүүдтэй биднийг уулзуулав. Пол Потын яргалалаас азтай учралаар юм уу амь зулбан зайлсан тоотой хэдхэн сэхээтний нэг, ордны бүжигчин агсан нэг эмэгтэй тэр сургуульд хүүхдүүдийг цуглуулан ардынхаа бүжиг дууг зааж, ерөөс ардын дуу хуурын чимээ тасарч мэдэх байсан Пномпений цагаан шаргал орд харш, халуун орны мөнх ногоон модод дээгүүр хүүхэд багачуудын шингэн цэвэр дуу хангинах нь ард түмний үр үндэс тасраагүйн билэг тэмдэг болжээ. Төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан Кампучи ард улсын соёл боловсролын яамны санд хамгийн түрүүн олон мянган өнчин өрөөсөн хүүхдүүдийг сургууль, асрамжийн газар авч, 1980 оны хичээлийн жилд сая илүү хүүхдийг хамран бага дунд сургуулийн хичээлийг нээх бололцоотой болсноо улс орныхоо амьдралыг хэвийн болгох талаар бүхнийг шавхан дайчилж байгаа ардын засгийн нэг гол амжилт гэж ярьсан юм. Тийнхүү шинэ амьдрал хүүхдүүдийн төлөө тэмцлээр эхэлжээ. Сианукийн ордны гоёмсог танхимд Рамаяны үлгэрээр хийсэн бүжиг наадам үзүүлж, цангинасан шингэн дуугаар дуулалдах хөөрхөн багачуулыг хараад хоолой зангиравч, нэгэнт үр хүүхдийнхээ төлөө санаа тавьж, дуу хуураа сэргээсэн орон, жинхэнэ ардын засаг төрийнхөө удирдлагаар сэргэн мандаж, Ангкорын таван цамхагт улаан тугаа гудайлгалгүй мандуулна гэдэгт итгэж байлаа.